

**ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр, Лхагва гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	1-2
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	3-16

<i>1.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/</i>	3-16
--	------

**Монгол Улсын Их Хурлын 2023 оны хаврын ээлжит чуулганы
Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны
07 дугаар сарын 05-ны өдөр /Лхагва гараг/-ийн
хуралдааны товч тэмдэглэл**

Үйлдвэржилтийн бодлогын байнгын хорооны дарга Т.Энхтүвшин ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр хуралдаан 11 цаг 41 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

*Томилолттой: Г.Амартүвшин, Ц.Анандбазар, Г.Ганболд, Ц.Туваан;
Чөлөөтэй: А.Адъяасүрэн, С.Ганбаатар, Ж.Эрдэнэбат.*

Нэг. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, “Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэл батлах тухай” Улсын Их Хурлын тогтоолын төсөл /Засгийн газар 2023.06.16-ны өдөр өргөн мэдүүлсэн, хоёр дахь хэлэлцүүлэг, санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэл-нийцлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Д.Энхболд, Сангийн яамны Төрийн сангийн газрын дарга Ч.Тавинжил, мөн яамны Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Ч.Чимидсүрэн, мөн газрын Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Ж.Дэлгэржаргал, Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн М.Алтанхорол, Санхүү, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Н.Мөнхсүх, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, мөн яамны Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга С.Должинсүрэн, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, мөн яамны Ахлах шинжээч, ерөнхий нягтлан бодогч Г.Алтангэрэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Г.Батбаяр, мөн яамны Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Б.Отгонцэцэг, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалсүрэн, мөн яамны Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Ц.Болорчулуун, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрын дарга М.Дондогдорж, Яамны ерөнхий нягтлан бодогч П.Энхбаяр, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, мөн яамны Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга З.Мөнх-Оргил, ерөнхий нягтлан бодогч Г.Гантуяа, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хууль, эрх зүйн газрын Байнгын хорооны асуудал хариуцсан хэлтсийн Үйлдвэржилтийн бодлогын байнгын хороо хариуцсан ахлах зөвлөх Б.Гандулам, референт Б.Ууганцэцэг, Хяналт шалгалт, үнэлгээний газрын Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Ч.Сарантуяа нар байлцав.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх танилцуулгыг Эрүүл мэндийн сайд С.Чинзориг, Төсвийн гүйцэтгэлийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Д.Занданбат нар танилцуулав.

Аудитын дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн Н.Наранбаатар, Г.Дамдинням, Б.Пүрэвдорж нарын тавьсан асуултад Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Магнайсүрэн, Зам, тээврийн хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Тавинбэх, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Т.Жамбалсүрэн, Ашигт малтмал, газрын тосны газрын дарга Л.Баярмандал нар хариулж, тайлбар хийв.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 39 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 58 минут үргэлжилж, 17 гишүүнээс 10 гишүүн хүрэлцэн ирж, 52.9 хувийн ирцтэйгээр 12 цаг 39 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН
БАЙНГЫН ХОРООНЫ ДАРГА

Т.ЭНХТҮВШИН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.ОТГОНДЭЛГЭР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2023 оны 07 дугаар сарын 05-ны өдөр,
Лхагва гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим
11 цаг 41 минут.

ҮЙЛДВЭРЖИЛТИЙН БОДЛОГЫН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Т.Энхтүвшин:

Гишүүдийнхээ энэ өдрийн мэндийг хүргэе.

Хуралдаанд ирсэн гишүүдээ танилцуулъя. Улсын Их Хурлын гишүүн Аубакир гишүүн, Улсын Их Хурлын гишүүн Батжаргал гишүүн, Батлут гишүүн, Бат-Эрдэнэ гишүүн, Дамдинням гишүүн, Наранбаатар гишүүн, Раднаасэд гишүүн, Тэмүүлэн гишүүн, Цогтгэрэл гишүүн, Энхтүвшин гэсэн гишүүд ирсэн байна.

Хуралдаанд оролцож байгаа гишүүд олонх нь ирсэн тулд хуралдааныг нээснийг мэдэгдэж байна.

Байнгын хорооны хуралдааны хэлэлцэх асуудлыг танилцуулъя. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан, Засгийн газар 2023 оны 6 дугаар сарын 16-ны өдөр өргөн мэдүүлсэн хоёр дахь хэлэлцүүлэг. Санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд хүргүүлнэ гэсэн байж байгаа.

Хэлэлцэх асуудалтай саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудал дээр саналтай гишүүн байхгүй тул асуудалдаа оръё.

1.Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулъя.

Ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг танилцуулъя. Ажлын хэсгийн бүрэлдэхүүнд Эрчим хүчний сайд Чойжилсүрэн, Эрүүл мэндийн сайд Чинзориг, Сангийн дэд сайд байна уу. Сангийн дэд сайд Мөнгөнчимэг, Монгол Улсын Ерөнхий аудитор Занданбат, Монгол Улсын Ерөнхий аудиторын орлогчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Наранчимэг, Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлагын зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор Самбууням, Үндэсний аудитын газрын Гүйцэтгэлийн аудитын газрын захирал, тэргүүлэх аудитор Энхболд, Сангийн яам-Төрийн нарийн бичгийн дарга байхгүй байгаа юм байна тээ. Төсвийн байнгын хороон дээр байж байгаа юм байна. Төрийн нарийн бичгийн дарга Ж.Ганбат, Төрийн сангийн дарга Тавинжил, Хөгжлийн санхүүжилт, хөрөнгө оруулалтын газрын дарга Чимэдсүрэн, Санхүү, тайлан бүртгэлийн хэлтсийн дарга Мөнхсүх, Сангийн яамны Төсвийн хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга Дэлгэржаргал, Төрийн сангийн газрын Санхүүжилт, тайлан бүртгэлийн хэлтсийн мэргэжилтэн Алтанхорол, Барилга, хот байгуулалтын яамны Төрийн нарийн бичгийн дарга Магнайсүрэн, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Должинсүрэн, Зам тээвэр, хөгжлийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, ахлах шинжээч, ерөнхий нягтлан бодогч Алтангэрэл, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам-Төрийн нарийн бичгийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Батбаяр, Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Отгонцэцэг, Хүнс, хөдөө аж ахуйн яам Төрийн нарийн бичгийн дарга Жамбалцэрэн, Бодлого, төлөвлөлтийн газрын дарга Болорчулуун, Хөнгөн үйлдвэрийн бодлогын газрын дарга Дондогдорж, Мал эмнэлгийн ерөнхий газрын дарга Нарантуяа, яамны ерөнхий нягтлан бодогч Энхбаяр, Эрчим хүчний яам Төрийн нарийн бичгийн дарга Тавинбэх, Санхүү, хөрөнгө оруулалтын газрын дарга Мөнх-Оргил, яамны ерөнхий

нягтлан бодогч Гантуяа ийм бүрэлдэхүүн цугласан байж байна.

төлөгдөх цэвэр зээлд 14.5 тэрбум төгрөгийг зарцуулсан байна.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлангийн талаарх танилцуулгыг Эрүүл мэндийн сайд Чинзориг сайд танилцуулна. Чинзориг сайдын микрофоныг өгье.

С.Чинзориг: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хуулийн хугацаанд нэгтгэн гаргаж, Төрийн аудитын төв байгууллагаар аудит хийлгэн Монгол Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 3-ны өдөр анхны хэлэлцүүлэгт танилцуулсан билээ.

Монгол Улсын нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийн дүн 2022 онд 17.1 их наяд төгрөг, нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 18.1 их наяд төгрөг, нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт тэнцэлд 1 их наяд төгрөгийн алдагдалтай гарч, төлөвлөгдсөн дүнгээс 1.8 их наяд төгрөгөөр буурсан ба сүүлийн 3 жил дараалан төсвийн алдагдлыг үе шаттайгаар буурууллаа.

Монгол Улсын нэгдсэн төсвийн гүйцэтгэл Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан тус Байнгын хороонд харьяалагдах Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, Уул уурхай, хүнд үйлдвэрлэлийн сайд, Эрчим хүчний сайд, Барилга, хот байгуулалтын сайдын багцын нийт 150 байгууллагын төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланг нэгтгэн гаргасан болно.

Нэгдсэн төсвийн гүйцэтгэлээр тус Байнгын хорооны төсвийн ерөнхийлөн захирагчдын нийт зарлага ба цэвэр зээлийн дүн 644.6 тэрбум төгрөгийн гүйцэтгэл гарч, урсгал зардалд 287.7 тэрбум төгрөг, хөрөнгийн зардалд 342.4 тэрбум төгрөг, эргэж

Нийт зарлага ба цэвэр зээлийн дүнгийн 35.3 хувь буюу 239.2 тэрбум төгрөгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайд, 35.3 хувь буюу 227.4 тэрбум төгрөгийг Барилга, хот байгуулалтын сайд, 21.5 хувь буюу 138.8 тэрбум төгрөгийг Эрчим хүчний сайд, 6.1 хувь буюу 39.1 тэрбум төгрөгийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын зарлага эзэлж байна.

Улсын төсвөөс 629.7 тэрбум төгрөгийн санхүүжилтийг олгосон бол төсөвт байгууллагын өөрийн орлогоор 54.3 тэрбум төгрөгийн эх үүсвэрийг бүрдүүлсэн байна.

Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд та бүхэн 2022 оны төсвийн гүйцэтгэлийн үр дүнгийн тоон үзүүлэлтүүд болон буцагдах холбогдох тайлан, танилцуулга, аудитын дүгнэлтүүдтэй танилцаж Төсвийн тухай хуулийн дагуу Монгол Улсын 2022 оны төсвийн гүйцэтгэлийг батлах тухай Улсын Их Хурлын тогтоолын төслийг хэлэлцэж өгөхийг хүсэж байна.

Баярлалаа.

Т.Энхтүвшин: Чинзориг сайдад баярлалаа. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэл, нэгдсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор Занданбат танилцуулна. Занданбат даргын микрофоныг өгье.

Д.Занданбат: Байнгын хорооны дарга, Улсын Их Хурлын эрхэм гишүүд ээ,

Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрх, Төсвийн тухай хуулийн дагуу төсвийн ерөнхийлөн захирагчдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Тус Байнгын хороонд харьяалагдах төсвийн ерөнхийлөн захирагчдын санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл болон улсын төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд хийсэн аудитын талаар товч танилцуулъя.

1.Барилга, хот байгуулалтын сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд 33 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 26 байгууллагад дүгнэлт гаргаж, 7 байгууллагыг аудитын түүвэрт хамруулаа.

Аудитаар хязгаарлалттай дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 21 байгууллагад өөрчилдөггүй, 4 байгууллагад хязгаарлалттай, 1 байгууллагад сөрөг дүгнэлт өгч, нийт 520.7 тэрбум төгрөгийн 97 зөрчил илэрснээс 0.1 тэрбум төгрөгийн 14 төлбөрийн акт тогтоож, 516.3 тэрбум төгрөгийн 38 албан шаардлага хүргүүлж, 2.6 тэрбум төгрөгийн 42 зөвлөмж өгч, 1.7 тэрбум төгрөгийн 3 зөрчлийг хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй нийт 1.3 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 13 байгууллагын төсвийн захирагч нарт хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн. Нийцлийн асуудлаар 396.1 тэрбум төгрөгийн 30 зөрчил илэрснээс 1 төлбөрийн акт, 95.3 тэрбум төгрөгийн 10 албан шаардлага, 300.8 тэрбум төгрөгийн 19 зөвлөмж өгсөн.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 342.3 тэрбум төгрөгийн 28 алдаа илэрснээс аудитын явцад 291.1 тэрбум төгрөгийн 23 алдааг залруулж, 51.2 тэрбум төгрөгийн алдааг дахин давтан гаргахгүй байх 5 зөвлөмж өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар нийт 1 их наяд 84.2 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 223.2

тэрбум төгрөгийн санхүүжих дүнтэй 227 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр баталсан.

Үүнээс шилжин хэрэгжих 500.8 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 111, шинээр хэрэгжих 583.3 тэрбум төгрөгийн төсөвт өртөгтэй 116 төсөл, арга хэмжээ байна.

2.Зам тээврийн хөгжлийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын 2022 оны санхүү нэгтгэсэн тайланд 33 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 31 байгууллагад дүгнэлт гаргаж, 2 байгууллагыг түүвэрт хамруулсан байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 19 байгууллагад өөрчлөлтгүй, 12 байгууллагад хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Аудитаар нийт 143 тэрбум төгрөгийн 268 зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн зөрчилд 42 төлбөрийн акт тогтоож, 138.5 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах 94 албан шаардлага хүргүүлж, 4.1 тэрбум төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 124 зөвлөмж өгч, эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцуулах 6 албан шаардлагыг хүргүүлж, 0.2 тэрбум төгрөгийн 2 асуудлыг хууль, хяналтын байгууллагад шилжүүлэхээр шийдвэрлэсэн байна.

Үүнээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй нийт 9.8 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 18 байгууллагын төсвийн захирагч нарт хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

Нийцлийн асуудлаар 36.9 тэрбум төгрөгийн 63 зөрчил илэрснээс 17 тэрбум төгрөгийн 26 албан шаардлага, 19.9 тэрбум төгрөгийн 36 зөвлөмж өгч, эрх бүхий албан тушаалтанд хариуцлага тооцуулах 1 албан шаардлага хүргүүлсэн.

Аудитаар нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой нийт 85.2 тэрбум төгрөгийн 82 алдаа илэрснээс 84.7 тэрбум төгрөгийн 73 алдааг аудитын явцад залруулж, 0.5 тэрбум төгрөгийн 9 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өгөв.

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагын санхүүгийн нэгтгэсэн тайланд 64 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 60 байгууллагад дүгнэлт гаргаж, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн бөгөөд харьяа 48 байгууллагад өөрчилдөггүй, 10 байгууллагад хязгаарлалттай, 2 байгууллагад сөрөг дүгнэлт өгсөн.

Нийт 495.8 тэрбум төгрөгийн 168 зөрчил илэрснээс 0.2 тэрбум төгрөгийн 21 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 492.9 тэрбум төгрөгийн 72 зөрчилд албан шаардлага хүргүүлж, 2.7 тэрбум төгрөгийн 75 зөрчилд зөвлөмж өгсөн. Үүнээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг хангаагүй нийт 300 сая төгрөгийн зөрчил гаргасан 16 байгууллагын төсвийн захирагч нарт хариуцлага тооцох албан шаардлага хүргүүлсэн.

Нийцлийн асуудлаар 1 тэрбум төгрөгийн 48 зөрчил илэрснээс 0.3 тэрбум төгрөгийн 21 албан шаардлага хүргүүлж, 0.7 тэрбум төгрөгийн 27 зөвлөмж өгсөн.

Аудитын явцад нягтлан бодох бүртгэл тайлагналтай холбоотой 20.2 тэрбумын 59 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Уул уурхайн хүнд үйлдвэрийн сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудад санхүүгийн нэгтгэсэн тайланд 25 байгууллагын санхүүгийн

тайланг нэгтгэсэн, 21 байгууллагад дүгнэлт гаргасан, 4 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн. Харьяа 9 байгууллагад өөрчлөлтгүй, 9 байгууллагад нь хязгаарлалттай, 3 байгууллагад сөрөг дүгнэлт өгсөн байна.

Аудитаар нийт 2 их наяд 492.2 тэрбум төгрөгийн 173 зөрчил илэрснээс 10 тэрбум төгрөгийн 22 төлбөрийн акт тогтоож, 516.2 тэрбум төгрөгийн 84 албан шаардлага хүргүүлж, 1 их наяд 938.9 тэрбум төгрөгийн 62 зөвлөмж өгч, эрхэлсэн ажилдаа хариуцлагагүй хандсан албан хаагчид хариуцлага тооцох 1 албан шаардлагыг хүргүүлсэн. Хууль, хяналтын байгууллагад 2 байгууллагын 27 тэрбум төгрөгийн асуудлыг шилжүүлсэн байна.

Үүнээс Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хүрээнд 1.2 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 17 байгууллагын төсвийн захирагч нарт хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

Нийцлийн асуудлаар 13 тэрбум төгрөгийн 33 зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 12 тэрбум төгрөгийн 13 албан шаардлага 1 тэрбум төгрөгийн 19 зөвлөмж өгсөн.

Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 3 их наяд 77.6 тэрбум төгрөгийн 83 алдаа илэрснээс аудитын явцад 3 их наяд 49 тэрбум төгрөгийн 65 алдааг залруулж, нягтлан бодох бүртгэлд холбоотой 28.6 тэрбум төгрөгийн 18 алдааг давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Эрчим хүчний сайдын эрхлэх асуудлын хүрээний байгууллагуудын санхүүгийн нэгтгэсэн тайланд 33 байгууллагын санхүүгийн тайлан нэгтгэгдсэнээс 32 байгууллагад нь дүгнэлт гаргаж, 1 байгууллагыг түүвэрт хамруулсан.

Төсвийн ерөнхийлөгчийн захирагчийн санхүүгийн нэгтгэсэн тайланд хязгаарлалттай дүгнэлт өгсөн. 25 харьяа байгууллагад өөрчлөлтгүй, 7 байгууллагад нь хязгаарлалттай дүгнэлт өгсөн.

Нийт 100.3 тэрбум төгрөгийн 156 зөрчил илэрснээс 0.5 сая төгрөгийн 25 төлбөрийн акт тогтоож, 94.4 тэрбум төгрөгийн 67 албан шаардлага хүргүүлж, 54.4 тэрбум төгрөгийн 61 зөвлөмж өгч, 2 зөрчилд хариуцлага тооцуулах албан шаардлагыг хүргүүлсэн. Хууль, хяналтын байгууллагад 1 асуудлыг шилжүүлсэн.

Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд 7.7 тэрбум төгрөгийн зөрчил гаргасан 8 байгууллагын төсвийн захирагч нарт хариуцлага тооцох албан шаардлагыг хүргүүлсэн.

Нийцлийн асуудлаар 96 тэрбум төгрөгийн 47 зөрчил илэрснээс 7 төлбөрийн акт тогтоож, 28.5 тэрбум төгрөгийн 28 албан шаардлага бичиж, 67.5 тэрбум төгрөгийн 12 зөвлөмжийг өгсөн. Нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой 547.1 тэрбум төгрөгийн 101 алдаа илэрснийг аудитын явцад залруулж, 82 алдааг залруулж, нягтлан бодох, бүртгэлтэй холбоотой 5.3 тэрбум төгрөгийн 19 алдааг давтан гаргахгүй байх талаар зөвлөмж өглөө.

Аудитын дүгнэлтээс нэн тэргүүнд дараах асуудлыг тоймлон танилцуулъя.

Төсвийн ерөнхийлөн захирагчдын хэрэгжүүлсэн хөтөлбөр, хөтөлбөрийн үр дүн, чанар, тоо хэмжээг төсвийн гүйцэтгэлтэй уялдуулан хяналт шинжилгээ, үнэлгээ хийж баталгаажуулахгүй байна.

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөрийн шалгуур үзүүлэлт хүрэх түвшин тодорхойгүйгээс улс, орон нутгийн төсвийн хөрөнгө

оруулалтаар хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээний үр дүнг бодитой үнэмлэх боломжгүй байна.

Төсөл, арга хэмжээний гүйцэтгэл, хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн болон зохиогчийн хяналт үр дүнгүй байна. Төсвийн ерөнхийлөн захирагчдын дотоод аудитын нэгж нь хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанд хяналт хийхгүй байгаа нь зөрчил арилахгүй байх гол шалтгааны нэг болж байна.

Орхигдсон болон олон жил үргэлжилж байгаа төсөл, арга хэмжээг богино хугацаанд ашиглалтад оруулах шийдлийг гаргахгүй байгаа нь төсвөөс санхүүжигдсэн 287.6 тэрбум төгрөг нь үр дүнгүй зарцуулагдах үр дагавар үүсэхээр байна.

Засгийн газрын шийдвэрээр төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүд төсвөөс санхүүжих нийгмийн шинж чанартай төсөл, арга хэмжээ бүтээн байгуулалтын ажлуудыг санхүүжүүлж байгаа нь төсвийн нэгдсэн бодлогын зарчим алдагдуулж байна.

Төсөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл, арга хэмжээг санхүүжүүлж байгаа нь хөрөнгө оруулалтын үр өгөөж буурах, мөн төсөвт ачаалал үүсэж буй талаар жил бүр хийгдэж буй аудитын өгсөн дүгнэлт, зөвлөмжийг сайн хэрэгжүүлэхгүй байгаа нь Төсвийн тухай хуульд заасан төсөвлөлтийн шаардлагыг хангахгүй зөрчсөн хэвээр байгааг дурдъя.

Анхаарал хандуулсанд баярлалаа.

Т.Энхтүвшин: Монгол Улсын Ерөнхий аудитор Занданбат даргад баярлалаа.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон аудитын дүгнэлттэй холбогдуулан асуух асуулттай гишүүд нэрээ өгнө үү.

Дамдинням гишүүнээр тасаллаа.
Наранбаатар гишүүний микрофоныг өгье.

Н.Наранбаатар: Та бүхэнд өглөөний мэнд хүргэе. Би зам засвар, арчлалтын талаар л асуулт асуух гэсэн юм. Энэ улсын чанартай авто замын засвар, арчилтад өнгөрсөн жил хэчнээн хэмжээний хөрөнгө ер нь тавигдав. Түүн дотроо Мандалговь-Даланзадгад чиглэлийн улсын чанартай авто замын засвар, арчилтад хэчнээн төгрөг тавьж, гүйцэтгэл нь ямар гүйцэтгэлтэй байсан юм. Энэ жил бас хэдий хэмжээний төсөв тавигдаж байгаа бол, одоо засварын ажил нь ямар ч байсан явагдаж л байна.

Тэгэхдээ бол бас явж байгаа ажлаас харах юм бол төсөв, санхүү нь бас дутагдалтай гэдэг асуудал бас яригдаж байгаа. Тэгээд энэ зам бол үндсэндээ Өмнөговь руу явж байгаа 2 боомт, уул уурхай, орон нутгийн зорчигч, иргэдийн явдаг гол зам. Олон жил эвдэрхий байснаас олон хүний эд хөрөнгө, эдийн засаг, амь насаараа хүртэл хохироож байгаа ийм л зам байгаа.

Гол энэ замын эвдэлж байгаа хүчин зүйл нь бол энэ Улаанбаатар хотыг утаагүй болгоход хэрэглэж байгаа энэ шахмал түлш, мидлингийн тээвэртэй холбоотой, даац хэтрүүлж ачиж явдагтай холбоотойгоор энэ зам засвар хийсэн ч гэсэн эргээд өвөлдөө эвдэрдэг. Хавар нь дахиад засвар хийдэг дахиад зун нь эвддэг. Ингээд улсын төсвийн хөрөнгө үргүй зарцуулагддаг ийм юм жилээс жилд мөнгө, хөрөнгө хийгээд л үрэн таран хийгээд байдаг ямар ч үр дүнгүй засварын ажил нь. Ийм асуудал байж байгаа юм.

Тэгээд саяхан бас тэр утаагүй түлшний үйлдвэрийн удирдлагуудын өгсөн ярилцлагыг сонссон. Харж байхад төмөр зам руу бүрэн шилжүүлээ гэсэн тийм зүйл ярьсан байна лээ. Энэ нүүрсний мидлингийнхээ тээврийг.

Тэгэхээр энэ хэр бодитой юм. Энэ зүгээр зорчигч тээврийн стандарт энэ замаар хүнд тээврийн нүүрс, автомашин явах тээвэр хийлгэдэг байдлаа хэзээ зогсоох юм. Төмөр зам руугаа яагаад шилжүүлэхгүй байгаа юм. Төмөр зам нь ашиглалтад ороод Зүүнбаяны төмөр зам нь нээлтээ хийгээд хэвийн ашиглагдаж байгаа гэж үзэж байгаа юм.

Тэгэхээр энэ тээврээ хэзээ төмөр зам руугаа 100 хувь шилжүүлэх юм. Шилжүүлж болохгүй байгаа бол яагаад энэ тээврийг тийш нь шилжүүлж болохгүй байгаа юм. Энэ жилийн засвар нь хэзээ дуусах юм, хэдий хэмжээний хөрөнгө тавигдсан юм, хэдийн дутагдалтай байгаа юм гэдэг дээр Зам тээврийн яам, Эрчим хүчний яамнаас хариулт авъя.

Т.Энхтүвшин: Зам тээврийн яам Төрийн нарийн бичгийн дарга Батболд дарга хариулах уу. Эрчим хүчний яам дараа нь бас хариулаад яваарайб Тавинбэх дарга байж байгаа. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофоныг өгье.

С.Батболд: Наранбаатар гишүүний асуултад хариулъя. Өнгөрсөн жил улсын хэмжээний зам засварын ажилд 55 тэрбум төгрөг тусгагдсан. Үүнээс энэ өнгөрсөн хугацаанд саяын таны асуусан Дундговийн чиглэлийн замд 3.2 тэрбум төгрөгөөр засвар, их засвар хийсэн. Энэ жил мөн ялгаагүй тийм хэмжээний 55 орчим, 55 тэрбум төгрөг энэ 23 онд зам засварын ажилд тусгагдсан.

Үүнээс энэ нийт зам хариуцагч байгууллагуудад хуваарилснаар Дундговь аймгийн яг энэ хэсгийн Дундговь АЗЗА-аа хариуцаж байгаа энэ хэсэг дээр 1.6 тэрбум төгрөг, Өмнөговь аймгийн хариуцаж байгаа хэсэг дээр 976 тэрбум төгрөг хуваарилагдсан байна.

Зам засварын ажил эхэлчихсэн явж байгаа. 978 сая төгрөг тийм. Зам засварын ажил бол хуваарийн дагуу

явагдаад 9 сарын 10 гэхэд бүх засвар дуусах ийм төлөвлөгөөтэй.

Хоёр дахь асуудал болохоор бид төмөр зам руу шилжих бүрэн боломжтой. Уул уурхайн яам, Эрчим хүчний яамд энэ шатахуун болон энэ утаагүй түлшний энэ түүхий эдийг аль болохоор төмөр замаар тээвэрлээч гэдэг ийм хүсэлтийг тавьж байгаа. Тээвэрлэлт бас эхэлчихсэн явж байгаа.

Мөн энэ дээр бас даац хэтрүүлж байгаа асуудлууд дээр бас тодорхой задрах боломжгүй ийм ачаанууд дээр сая энэ 6 сарын эхээр Засгийн газрын тогтоол гарч, зарим хэсэгт төлбөртэй явуулах ийм боломжуудыг нээсэн байгаа.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 7 дугаар микрофон. Ажлын хэсгийн 7 дугаар микрофоныг өгөөрэй.

Н.Тавинбэх: Гишүүний асуултад хариулъя. Сайжруулсан шахмал түлшний түүхий эд мидлингийг өнгөрсөн оноос эхлээд ялангуяа энэ жил бол төмөр замаар тээвэрлэх боломжийг бүрэн бүрдүүлсэн байгаа Тавантолгой түлшний хувьд. Ганцхан хүндрэлтэй асуудал бол энэ жилд 600 мянга орчим тонн мидлингийг тээвэрлэх 7 хоногт 300-аас доошгүй вагон тавьж өгөх, вагоны тавилт шаардлагатай тоонд хүрэхгүй байгаагаас болоод бид бол авто замаар тээвэрлэлтийг хийж байгаа. Өнөөдрийн байдлаар бол 200 орчим вагон тавьж байна. Энэ 200 орчим вагон бол жилийн нөөцийг бүрдүүлэхэд шаардлагатай тээврийн хэмжээ биш учраас бид зарим тохиолдолд тодорхой хэмжээнд авто-аар мидлингийн тээвэрлэлтийг хийж байна.

Би дахиад хэлье 7 хоногт дунджаар 300-аас доошгүй вагон тавьчихвал бид нар мидлингийн тээвэрлэлтийг авто замаар хийх шаардлагагүй болно гэдгийг хэлье. Вагоны тоо хүрэлцэхгүй байгаагаас бид хослуулж явж байгаа бол мэдээжийн хэрэг Улаанбаатар хотын сайжруулсан

шахмал түлшний хангамжийг тасалдуулахгүй байхтай холбоотой ийм авч байгаа арга хэмжээ.

Хэрвээ цаашидаа төмөр зам 7 хоногт 300-аас хүртэл вагон тавьж чадахгүй байвал бид нар авто-аар тээвэрлэж таарна. Тээвэрлэхдээ саяын Батболд даргын хэлдэг тээврийн даацын хэмжээг Монгол Улсын стандартад бариулах дээр анхаарч ажиллана гэдгийг хэлье.

Т.Энхтүвшин: Наранбаатар гишүүн хариулт хангалттай юу. Дамдинням гишүүн, Дамдинням гишүүний микрофоныг өгье.

Г.Дамдинням: Төсвийн гүйцэтгэл, 2022 оны төсвийн гүйцэтгэл ярьцааж байна бид нар. Энэ аудитын дүгнэлтийг сонсоход зохиогч захиалагчийн хяналт үр дүнгүй байна, дүгнэлтүүд хэрэгжихгүй байна гээд үнэхээр яг сонсёе гэж бодож байсан дүгнэлтийг хэлж байна л даа. Өнөөдөр Улаанбаатар хотод болж байгаа үйл явдлуудыг хар л даа. Авлигал хороолол гээд заваарсан юм голын ай савд гаргаад аваачаад барьчихсан. Энэ зүгээр захын жишээ нь байхгүй юу. Авлигал хорооллыг аваачаад Дунд голын голдирлыг боогоод тавьчихсан. Яг ийм хотхонуудаас болоод өнөөдөр энэ Улаанбаатар хотын тал нь үерт автчихсан бүгдээрээ л хохироод сууж байна.

Энэ Барилга, хот байгуулалтын яамныхан та нар Мэргээжлийн хяналт чинь салаад оччихсон. Би Улсын Их Хурлын гишүүний асуулга явуулсан. Та нар тодорхой, бодитой хариулт өгөөгүй байна лээ шүү дээ. Мэргээжлийн хяналт энэ тэрээ явуулаад зогсоо л доо наадхаа. Улайм цайм Байгаль орчин, аялал жуулчлалын яам нь Туул голын сав газрын захиргаатайгаа хууль зөрччихсөн байна гээд байхад та нар яахаараа барилга эрхлэх зөвшөөрлийг нь өгчихдөг юм. Та нар яахаараа тэр 9 давхраас дээш ч билүү барилгын зөвшөөрлийг танайх өгөөд бариулаад одоо ингээд урдаас

дээрэлхээд, томроод, доромжлоод, авлигалаа гайхуулаад, бяраа гайхуулаад. Цонхоо хийгээд энэ захиалгаа аваад дуусаж байгаа юм гэнэ лээ шүү дээ. Энэ үер усны аюулыг харж байгаа биз дээ та нар. Хот төлөвлөлт чинь танайх шүү дээ. Улаанбаатар хотын захиргаа руу яриад л ингээд л сууцгааж байдаг юм. Энэ газрыг ер нь хэзээ зогсоох юм та нар. Энэ дээр хариулт өгөөдхөөч.

Хоёрдугаарт Зам тээврийн яам барилгын улирал ингээд дууслаа, өө эхэлж байна. Тэгээд намар бид нар барилгын улирал дуустал цуглаж хурал хийж чадахгүй. Тэгээд зам маань ер нь хэр явна Дарханы зам. Би та хэдтэй очоод уулзсан та хэд маань бол зүтгээд л байгаа юм байна лээ, зүтгээд л байгаа юм байна лээ. Тэгэхдээ хэдүүлээ бас чуулган тарахаас өмнө энэ хүмүүст тодорхой мэдээлэл өгчихье яамныхан. Энэ жилдээ бол бүүр бүтэн дуусчихвал чадахгүй л юм байна лээ. Одоо байгаа байдлаараа бол. Тэгээд та нар энэ дээр бодит хариулт өгөөдхөөч. Багц тус бүрээр нь, тэгээд нийт дүнгээр нь. Энэ намар барилгын улирал дуусахад урсгал нээгээд цаашаа явж чадах юм уу, үгүй юү гэдэг дээр хариулт өгчих.

Гуравдугаарт Хөдөө аж ахуйн яам энэ арьс ширний цогцолбор Дарханы арьс ширний цогцолбор гээд зовлонгийн далай байна. Яах вэ манайхан, Хөдөө аж ахуйн яамныхан. Энэ аудитынхан ороод дүгнэлтээ гаргаад тэр хувийн хэвшлийнхэн нь авна гээд байгаа юм нь авна гээд л аваад төр рүү аваад тэгээд үргэлжлүүлнэ гээд ярьж байсан. Одоо буцаад хувийн хэвшлээр хийгээд явъя гэдэг рүүгээ л орж байгаа юм байна л даа.

Тэгээд энэ арьс ширний цогцолбор дээр та нар ер нь ямар ахиц гаргаад байгаа юм бэ. Энэ зөвхөн Дарханы юм биш байхгүй юу. Энэ нь Монголын нийт малчдын хүлээж байгаа юм. Малчид малынхаа түүхий эдийг аваачиж боловсруулж, үнэ өртгөө өсгөж, амьдрал ахуйгаа дээш нь болгох гээд хүлээгээд

сууж байгаа юм байхгүй юу. Тэгэхээр энэ дээр та нар ер нь ямар ахиц гаргаж байна. Байнга л хиллэх юм. Тэгээд мундаг өндөр дүнтэй, хувьтай тайлан оруулж ирнэ, аудит тэрийг нь харсан болно, бид нар энэчээ янхисан болно. Ингээд хэдэн биеэ хуураад л дуусаж байгаа байхгүй юу. Үйлдвэр баригдчихмаар байна шүү дээ. Юу болж байгаа юм. Энэ гурван асуултад хариулт авъя.

Т.Энхтүвшин: Барилга, хот байгуулалтын яам Магнайсүрэн дарга. Ажлын хэсгийн 7 дугаар микрофоныг өгөөрэй.

Дамдинням гишүүний асуултад хариулъя. Барилга, хот байгуулалтын яам Төрийн нарийн бичгийн дарга Магнайсүрэн байна.

С.Магнайсүрэн: Дунд гол дээр баригдаж байгаа энэ Акуа хороололтой холбоотой асуудалд асуулаа. Энэ хорооллын тухайд энэ газар олголтын асуудал нь нэлээн бараг 10 гаруй жилийн урьд өгөгдөөд, шүүхийн шийдвэр нийслэлтэй холбогдуулаад хэд хэдэн удаа гараад, хамгийн сүүлд шүүхийн шийдвэр хүчин төгөлдөр болоод тэгээд энэний дагуу нийслэлээс энэ газар олгогдсон ийм байдалтай байдаг юм байна.

Тухайн барилга дээр газар барилга барихтай холбоотой ажил эхлэх зөвшөөрлийг бол өнөөдөр хүчин төгөлдөр үйлчилж байгаа Засгийн газрын тогтоолын дагуу Барилга, хот байгуулалтын яам онцгой түвшилтэй барилга гэдгээрээ өгсөн ийм байгаа. Ингээж өгөхөд бол энэ Засгийн газрын тогтоолоор бид яг байх ёстой баримт бичиг, бүрдлийг нь хянаад ингээд өгдөг. Энэ дагуу өнөөдөр бидэн дээр судлагдаж байгаа зүйл бол байгаль орчны үнэлгээ тодотгогдсон байх ёстой юу, үгүй юү гэдэг асуудал дээр л манай холбогдох эрх бүхий бас асуудлыг шийдсэн удирдах ажилтнууд бас энэ дээр бас яаж байгаа, шалгагдаж байгаа. Түүнээс биш бусад баримт бичгийн хувьд бол бүрдэл бүрэн

байсан учраас энэ бол өгөгдсөн ийм байдалтай байж байгаа.

Тэгээд Барилга, хот байгуулалтын сайдын бас тушаалаар энэ дээр дахин шалгаж, үнэлгээ хийх ийм ажил бас хийгдэж байгаа. Тэгээд нарийвчилсан мэдээллийг бас танд би дахиад өгье.

Т.Энхтүвшин: Зам тээврийн яам Батболд Төрийн нарийн бичгийн дарга. 1 номерын микрофоныг өгөөрэй.

С.Батболд: Дамдинням гишүүний асуултад хариулъя. Өнөөдрийн байдлаар Дарханы зам дээр нийтдээ энэ он гарснаар 907 хүн, 400 машин механизм ажиллаж байна. 109 км-ийн цементээр бэхжүүлсэн суурь, 32 км-ийн асфальтан хучилтын ажил ажил эхэлснээс хойш хийгдээд явж байна.

Азийн хөгжлийн банкны гүйцэтгэлийг 1 дүгээр багц 94.13 хувьтай, 2 дугаар багц нь 72.15 хувьтай, нэг ажлын хоцрогдол нь 21 орчим хувиар хоцорч явна. 3 дугаар багц 94.39 хувьтай, 4 дүгээр багцын ажил 60.4 хувьтай, 16 хувиар хоцорч явна. 5 дугаар багц 88 хувьтай, нийт ажлын гүйцэтгэл 78.7 хувьтай явж байна. Эй Ди Би-гийн ажил бол энэ ондоо ер нь бүрэн дуусна. Зүгээр жижиг нэмэлт тоноглолын ажлуудаас бусад нь хучилтууд бүрэн дуусаад явчихна.

Европын сэргээн босголт банкны төслөөр хийгдэж байгаа ажлын 1 дүгээр багц нь 75.82 эднийх 12 орчим хувийн хоцрогдолтой явж байна. 2 дугаар багц нь 51.58 хувьтай, 12.13 хувийн хоцрогдолтой явж байна. 3 дугаар багц 45.18 эд нар төлөвлөгөөнөөсөө 3.3 хувиар илүү явж байна. 4 дүгээр багцын ажил 53.03 хувьтай, 20 орчим хувийн хоцрогдолтой. 5 дугаар багцын ажил 62.6 хувьтай явж байна. Мөн ялгаагүй гэрээгээр энэ хучилт бол энэ хугацаанд энэ хоёр төсөл хоёулаа энэ оны 11 дүгээр сарын дунд гэхэд бүрэн дуусна.

Т.Энхтүвшин: Хөдөө аж ахуй 1 номерын микрофон.

Т.Жамбалсүрэн: Дамдинням гишүүний асуултад хариулъя. Хүнс, хөдөө аж ахуйн яамны Төрийн нарийн бичгийн дарга Жамбалсүрэн.

Дархан арьс ширний цогцолбор үйлдвэр технологийн парк бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх чиглэлээр Үйлдвэрчний байнгын хорооны 2022 оны 10 сарын 26 дугаар хуралдаанаар Байнгын хорооны тогтоол гарсан Засгийн газарт чиглэл өгөх тухай.

Үүнтэй холбоотой төслийн бүтээн байгуулалтын үеийн түр цахилгаан хангамж, худаг, оффисын барилга бүтээн байгуулалтын эхлүүлэх ажлын хүрээнд ажлуудаа эхлүүл эхлүүлсэн байгаа. 25 бүтээн байгуулалтын ажил хийгдэх 25 га газрын бүрэн чөлөөлөөд, цэвэрлээд, бүтээн байгуулалтын ажил хийгдээд эхлүүлэхэд бэлэн болгочихсон.

Цогцолборын бүтээн байгуулалтын үеийн цахилгаан хангамж буюу 800 квт-ын хүчин чадалтай дэд өртөөний угсралтын ажлыг бүрэн дууссан. Мөн улсын комиссоор хүлээлгэн хүлээж аваад ингээд ажиллаж байгаа.

Цогцолборын цэвэрлэх байгууламжийн барилгын зураг төсөв боловсруулах ажил өнөөдрийн байдлаар 90 хувийн гүйцэтгэлтэй, байгаль орчны нарийвчилсан үнэлгээ боловсруулах ажлууд бол хийгдээд явж байгаа. Дэд бүтцийн ажлын зураг боловсруулах ажилд 40 хувийн гүйцэтгэлтэй, агуулах барилгын зураг төсөл боловсруулах ажилд 90 хувийн гүйцэтгэлтэй ийм түвшинд явж байгаа.

Нэгдсэн дүнгээр нь аваад үзэх юм бол 22 оны зорилтот түвшин бол ТЭЗҮ бол 100 хувь хийгдчихсэн, зураг төсөл боловсруулах ажил нэгдсэн дүнгээрээ 90 хувийн гүйцэтгэлтэй явж байгаа нөхцөл байдалтай байгаа. Хувийн хэвшлийн

хөрөнгө оруулалтаа бас арьс ширний цогцолбор барилгын ажил эхлээд явж байсан. Энэ ажил хууль хяналтын байгууллагууд дээр хянагдаад Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Хөгжлийн банк, хувийн хэвшлийн оролцоотой хамтарсан ажлын хэсэг гарсан.

Үүнтэй холбоотой Үндэсний аудитын газар 2021 онд дүгнэлт гаргасан. Энэ дүгнэлтийг хөрөнгийн дахин үнэлгээ дээр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийгдсэн аж ахуйн нэгжүүд энэ хөрөнгө оруулалтыг хүлээн зөвшөөрөхгүй, энэ дүнг хүлээн зөвшөөрөхгүй гэдэг байдалтай хандаж ирсэн. Үүнээс хойш хууль, хяналтын байгууллагуудаар хянагдаад явж байгаа.

Сүүлд 2022 он, 23 оны 22 оны 10 сард байгуулагдсан хамтарсан ажлын хэсэг Барилга, хот байгуулалтын яам, Эрчим хүчний яам, Барилгын хөгжлийн төв хамтарсан ажлын хэсэг гарсан. Үүнтэй холбоотой дахин үнэлгээ хийсэн. Дахин үнэлгээгээр 21 тэрбум гэж хөрөнгийн үнэлгээг дүгнэсэн.

Хувийн хэвшил бол 21 тэрбум төгрөгийн хөрөнгийн үнэлгээгээ улсад Хөгжлийн банкандаа шилжүүлээд өгчихье. Хөгжлийн банк нь энэ бүтээн байгуулалтын ажлыг Хүнс, хөдөө аж ахуйн яаманд шилжүүлж өгье гэдэг байдлаар анхны хэлцлийг хийсэн.

Өнөөдрийн байдлаар гээд тэгэхэд хувийн хэвшил өнөөдөр гээд тэгэхэд 21 тэрбум төгрөгийн хөрөнгийн үнэлгээг одоо бид нар хүлээн зөвшөөрөх бололцоогүй байна гэдэг ийм мэдээллийг дахин ирүүлчхээд байгаа. Энэ дээр Хөгжлийн банк хувийн хэвшлийнхэн дахин сууж эцэслэх ёстой.

Хүнс, хөдөө аж ахуйн яамны хувьд энэ хөрөнгийн маргаан нь нэг талдаа шийдвэрлээд төрийн өмчид шилжүүлээд Хөгжлийн банкнаас Хүнс, хөдөө аж ахуйн яаманд шилжүүлээд ирэх юм бол Дархан арьс ширний цогцолбор бүтээн

байгуулалт, хөрөнгө оруулалттай холбоотой цогцолборын үйлдвэрлэл дээр нэгтгээд, хийгээд явах бололцоотой байгаа.

Нөгөө талаараа Байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу хөрөнгө оруулалтын асуудал дээр Эрдэнэт үйлдвэрийн ноогдол ашигаас хөрөнгө оруулалтыг санхүүжүүлэх ийм хуваарь гарсан. Хөрөнгө оруулалтуудын хувьд 21 оны байдлаар 50 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалт шийдэгдсэн. 23 оны байдлаар төрийн өмчит компаниудын нэгтгэлтэй холбоотой төлөөлөн удирдах зөвлөл дээр энэ хөрөнгийн маргаанууд шийдэгдсэний дараа санхүүжүүлнэ гэсэн байдалтай хөрөнгө оруулалтад түдгэлзсэн ийм нөхцөл байдалтай байж байгаа.

Т.Энхтүвшин: Дамдинням гишүүн.

Г.Дамдинням: Хөдөө аж ахуйн яамныхан энэ арьс ширний цогцолбор дээр ингээд л хувийн хэвшлийнхний ярьсан, хийсэн юмнуудыг бас оруулаад л, тайлбарлаад л явдаг юм. Та нар хэзээ дуусгаад л хэлчих. Наа чинь үлгэр шиг л юм яваа шүү дээ. Очоод хар л даа. Юу ч байхгүй шүү дээ. Энэ ширээн дээр яриад байгаа шиг гоё тоонууд чинь байхгүй шүү дээ наана чинь. Хэзээ өгөх тоогоо хэлчих, он сараа хэлчих. Бид нар зөндөө амлаж байгаад наадхыг чинь гараад ирчихсэн. Чи энэ та нарын засагт ажиллаж, зүтгэж байгаа хүмүүс бүгдээрээ энэ Засгийн газрын үйл ажиллагааныхаа хөтөлбөрийг биелүүлэх ёстой шүү дээ.

Хоёрдугаарт Барилга, хот байгуулалтын яамныхан энэ даварсан авлигал хорооллоо болиул. Та нарт бүрэн эрх чинь байгаа шүү дээ. Төрийн хяналтын бүх чиг үүргийг салгаад бид нар мэргэжлийн хяналтыг танай яаманд өгчихсөн шүү дээ хуулиар. Зогсоо л доо та нар. Толгой дээрээ гаргачихсан энэ хэдэн юмнуудаа болиул л даа. Энэ Улаанбаатар хотоо хар л даа. Ямар

юмны хот вэ. Баас, шээсэндээ дарагдсан үертэй автаад байж байна шүү дээ энэ. Хэзээ зогсоох юм та нар энийг.

Т.Энхтүвшин: Хөдөө аж ахуйн яам, дараа нь Барилга, хот байгуулалтын яам. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофоныг Хөдөө аж ахуй.

Т.Жамбалсүрэн: Гишүүний асуултад тодруулж хариулъя. Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамны тухайд Дархан арьс ширний цогцолбор үйлдвэр технологийн парк байгуулах бүтээн байгуулалтын ажилтай холбоотой зураг төсөл, холбогдох бичиг баримтуудыг бүрэн бэлдчихсэн, хөрөнгө оруулалтын асуудал бүрэн шийдэгдсэн тохиолдолд дэд бүтцийн ажлуудыг эхлүүлэх бололцоотой байгаа. Байнгын хорооноос өгсөн чиглэлийн дагуу хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар хийсэн ажилтай нэгтгээд яв гэсэн чиглэл ирсэн учраас Засгийн газар дээр нэгдсэн байр суурь гаргаад энэ ажил явна.

Т.Энхтүвшин: Хэзээ дуусах юм бэ. Хугацаа хэлж өгөөч гээд байна шүү дээ. Тодорхой хугацаа, тийм. Барилга, хот байгуулалтын яам. Хөдөө аж ахуйн яам тодорхой хариулт хэлээдэх. Хэзээ дуусах юм. Хэзээ дуусгахаар зорьж байгаа юм. Тэр асуудлаар л тодорхой хэлээдэх. Ажлын хэсгийн 1 дүгээр микрофон.

Т.Жамбалсүрэн: Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хүрээнд 2024 оны 12 сарын 31-ний дотор энэ бүтээн байгуулалтын ажил хийгдээд ашиглалтад орох ёстой. Бидний хувьд зураг төсөл, техникийн хүчин чадал бэлэн байдлууд бүрэн хийгдсэн учраас хөрөнгө оруулалтын асуудал шийдэгдсэн тохиолдолд төлөвлөгөөний дагуу бүтээн байгуулалтын ажлыг хийнэ.

Т.Энхтүвшин: Ажлын хэсгийн 7 дугаар микрофон. Барилга, хот байгуулалтын яам.

С.Магнайсүрэн: Дамдинням гишүүний асуултад тодруулж хариулъя. Энэ хорооллын асуудал бол энэ бас төрийн бус байгууллагууд бас хууль, хяналтын байгууллагад хандаад бас багагүй хугацаанд явсан. Тэгээд бас энэ хууль, хяналтын байгууллагуудаас эцэслэж шийд гараагүй явж байгаа юм.

Бид бол тэр цаад талын хэсэг буюу хорооллынх нь зүүн талынх нь усан паркийн хэсгийг нь бүрэн зогсоочихсон байгаа юм. Наад орон сууцын хороолол дээр нь бол бас шалгалтууд ороод бас тодорхой үндэслэлээр уг нь зогсоох ёстой. Тэгэхдээ яг тэрийг бол шийдээгүй байгаа. Тэгэхдээ бид өнөөдрийн энэ нөхцөл байдлаас энэ хурлын дараа бас бид нар бөөгнөрч хуралдахаар болж байх шиг байна. Энэ үер усны байдалтай холбогдуулаад. Энэ талыг бас давхар ярья.

Т.Энхтүвшин: Дамдинням гишүүн тодруулаадахъя.

Г.Дамдинням: Магнайсүрэн дарга Барилга, хот байгуулалтын яамныхан би одоо наад авлигал хорооллыг чинь сууриа тавьж байхаас нь эхлээд бүтэн жил гаруй хугацаанд та нартай зууралдаж байна. Ямар ч хариу байхгүй, ашигүй нэг юм байгаль хариуг нь өгч байна л даа. Байгаль хариуг нь өгч байна. Хэдэн биеийнхээ нүдийг аниад их сайхан явж байсан. Одоо яг бодит байдал яг харуулж байгаа байхгүй юу. Яг ийм болно гэж мэргэжлийн яам, Байгаль орчны яам ч хэлж байсан, би ч хэлж байсан, хүмүүс ярьж байсан. Цутгалтынх нь үед 18 настай хүүхэд дарагдаад үхсэн та нар очиж зогсоогоогүй л байхгүй юу яамныхан. Өнөөдөр энэ үер ус болж байна. Зогсоо л доо. Улсын дээд шүүх дээр хэрэг үүсчихсэн явж байгаа. АТГ дээр хэрэг үүсчихсэн явж л байгаа юм байна лээ шүү дээ надад ирсэн хариугаар. Та нарт зогсоох бүх эрх нь байгаа шүү дээ. Наадхаа зогсоо, давгарчихсан юмнуудыг болиулах хэрэгтэй шүү дээ. Дараа дараачийнх нь хүлээгээд сууж байгаа шүү дээ. Хийнэ гээд.

Т.Энхтүвшин: Пүрэвдорж гишүүн уул нь асуулт асууна гээд хажуу талын Байнгын хороо руу орчихлоо. Очоод дуудаадах даа. Тийм, ороод ирэх биз.

Тэгээд Хүнс, хөдөө аж ахуйн яамныхан бас нэг юм дээр анхаараарай та хэд маань. Нөгөө хувийн хэвшлийн барьж байсан 160 га байх аа Дамдинням гишүүнээ дэд бүтцийг нь хийчихсэн. Хажууд нь Хүнс, хөдөө аж ахуйн яам төрийн өмчтэй компани байгуулаад 25 га газар дээр ингээд зураг төсөл хийгээд, дэд бүтэц татаад ингээд яваад байгаа юм. Тэгээд энэ зураг төсөл хийсэн мөнгийг нь хэн төлөх юм, тэнд байгаа төрийн өмчтэй компанийн санхүүжилтийг хэн олгоод явж байгаа юм. Тэр 04-ийн шугам ч гэлүү татсан байна гэсэн. Тэр хөрөнгө мөнгийг нь хаанаас хэн шийдэх гээд байгаа юм бэ.

Хоёрдугаар асуудал түрүүн өөрийн чинь амнаас нэг үг гарчихлаа. Байнгын хорооны тогтоол дээр Эрдэнэтээс юу гэдэг юм мөнгө авах ямар ч асуудал тусгагдаагүй шүү. Тийм юм байхгүй байна шүү. Эрдэнэтээс 50 хэд билээ, 50 тэрбум төгрөг авна гэдэг асуудал яригдаагүй шүү Байнгын хороон дээр. Тэгэхээр энэ асуудал дээр бас нэлээн бодож байж хариулт хэлэхгүй бол.

Хоёрдугаарт Амарбаясгалан даргын өрөөнд хурал болсон байж байгаа. Тэр 25 га дээр хийж байгаад нэгдүгээрт зураг төслөө зогсоо гэдэг асуудал тавьсан шүү дээ. Тэр хувийн хэвшлийн хийж байгаад орхигдсон дэд бүтцийг дуусгаад тэр 160 га дээрээ л юу гэдэг юм цаашдаа үйлдвэр технологийн парк байгуулаад явна уу гэхээс биш дахиад 25 га дээр ингээд зураг төсөл хийгээд төсвийн мөнгийг ингэж үр ашиггүй зарцуулж болохгүй шүү дээ. Тэгээд энэ асуудал Засгийн газрын даргын хүрээнд хуралдаад шийдсэн байж байгаа шүү дээ. Эрдэнэтээс өгөх тэр 50 тэрбум төгрөгийн асуудлыг ч боль гэдэг

асуудал тавьсан байгаа Засгийн газраас Эрдэнэт рүү.

Тийм учраас наад ажлынхаа юу гэдэг юм уялдаа холбоог сайн хангаж байж, наадхаа бас дотооддоо сайн ярьж байж, Засгийн газартайгаа ярьж байж ийм нэгдсэн хариулттай болохгүй бол ингээд хоёр хариулт хэлээд ингээд явж болохгүй шүү дээ. 25 нь га нь явах гээд байгаа юм уу, 160 га нь явах гээд байгаа юм уу ингээд тодорхойгүй юм ярь ярьдгаа болих хэрэгтэй одоо бол та хэд.

Тэгээд энэ асуудал дээр онцгой анхаарахгүй бол наадах чинь одоо юу гэдэг юм нэлээн асуудал болж байгаа шүү. Хөгжлийн банк, Хүнс, хөдөө аж ахуйн яам, Үйлдвэржилтийн байнгын хороо, дээр нь Засгийн газрын дэд даргын өрөөнд хуралдаад энэ асуудлыг нэг мөр болгож шийд гэдэг ийм шийдийг гаргасан байгаа шүү гэдгийг бас хэлмээр байна.

Пүрэвдорж гишүүн асуултаа асууя.

Б.Пүрэвдорж: Үйлдвэржилтийн байнгын хороон дээр орж ирж үг хэлж байгаа нь бас шалтгаантай. Тэгэхээр хуурамч шатахууны хууль богиноор хэлбэл эсрэг хууль батлуулсан энийг Үндсэн хуулийн цэцэ хүчингүй болгосон байгаа. Тэгээд энэ миний гарт ингээд энэ Үндэсний аудитын газрын дүгнэлт байна. Шатахуунтай холбоотойгоор гаргасан. Түүгээр Монголд шатахууны үйлдвэр байхгүй гээд байгаа юм. Үйлдвэр байхгүй гээд гарчихсан байж байгаа юм. Төрийн байгууллагын дүгнэлт шүү.

Тэгэхээр би энэ Үйлдвэржилтийн байнгын хороо бас энэ үйлдвэр хариуцлагынхаа хувьд бас яг энэ өнөөдрийн байдлаар яг ялангуяа тэр Чойр дээр, Баян дээр, мөн түүнчлэн энэ Улаанбаатар хотод хаана ч гэлээ 49 ширхэг том агуулахтай тэр газарт үйлдвэр байна уу. Үйлдвэр байвал зургийг нь надаа өгчхөөч. Тэгвэл би тэмцлээ зогсоох гэж байгаа юм. Тэмцлээ зогсоомоор байна.

Өөрөөр хэлбэл би энэ Монгол Улсын Их Хурлын гишүүн Монгол Улсынхаа ард иргэдийн эрх ашгийн төлөө зүтгэх үүрэгтэй. Тэр хүмүүс стандартын чанартай шатахуун хэрэглэх ёстой. Дэлхий даяар улс орнууд Евро 5 руу орж байгаа. Евро 5-аар РРМ нь 10-тай л байдаг юм байна л даа. РРМ нь 10-тай байдаг. Гэтэл манайх 5000-аас дээш РРМ-тэй шатахуун хэрэглээд байна л даа. Тэгээд би эндээс уул уурхайн албан тушаалтнууддаа хамгийн том нь хэн байгаа юм. Тэр хүнээс нэг л юм хүсээд байгаа юм. Тэр Баян дээр, Чойр дээр, дээрээс нь энд Рашаант билүү дээ тэн дээр үйлдвэр байх юм бол надад зургийг нь өгчих. Очоод шалгаад өгөөч энэ та Үйлдвэржилтийн байнгын хорооны дарга та нэг хүмүүс ажлын хэсэг гаргадаг юм уу яадаг юм тийшээ үйлдвэр рүү энэ аягүй бол жижиг албан тушаалтнуудыг оруулахгүй байх.

Тийм учраас Үйлдвэржилтийн байнгын хорооноос энэ хаана ч, аль ч газар нэвтрэх эрхтэй тэр хүмүүсийг оролцуулсан, Их Хурлын гишүүдийг оролцуулсан тийм нэг ажлын хэсэг гаргаад тэгээд ийм үйлдвэр байна шүү дээ Пүрэвдоржоо гээд зургийг нь үзүүлчихвэл би тэгээд больчих гээд байгаа байхгүй юу. Тийм ээ.

Тийм учраас энэ бидний үндсэн үүрэг бол энэ Монголчууд эрүүл сайхан амьдрах ёстой, эд хөрөнгөөрөө хохирохгүй байх ёстой, энэ бүх зүйл дээр бид зүтгэх ёстой байхгүй юу даа. Тийм учраас энэ дээр яг энэ тэр газруудад үйлдвэр байна уу гэдгийг Уул уурхайн яамнаас асууж тодруулъя.

Т.Энхтүвшин: Уул уурхай яам хэн байна. Төрийн нарийн бичгийн дарга байгаа юм уу. Төрийн нарийн бичгийн дарга Батбаяр. Батбаяр байна уу, Отгонцэцэг. Уул уурхайн яамнаас хэн байгаа юм. Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга Отгонцэцэг мөн үү. За, Төрийн нарийн бичгийн дарга, дэд сайд чинь хаачихсан юм бэ. Дуудаадхаач.

Төрийн нарийн бичгийн дарга, дэд сайдаар харилцъя.

Ашигт малтмалын газрын тосны даргаа оруул даа.

Уул уурхай яам та хэд юу яахаар зөв юм байна даа. Дэд сайд чинь алга байна, Төрийн нарийн бичгийн дарга чинь байгаа юм уу. Баярмандал дарга. Пүрэвдорж гишүүнийг дуудчих. Ажлын хэсгийн 7 дугаар микрофон.

Л.Баярмандал: Пүрэвдорж гишүүний асуултад хариулъя. Ашигт малтмал, газрын тосны дарга Баярмандал байна. Тийм, энэ гадуур энэ хуурамч түлш гэж нэлээн их яригддаг юм. Энэ бол тэгэхдээ технологи талаасаа бас 100 хувь хуурамч гэхэд бас хэцүү юм байна лээ. Энийг гадаадад ч гэсэн хольдог. Зүгээр технологийн дагуу биш дутуу хольдог тийм асуудал бас яригддаг. Энэ бол Багануур болон Эрдэнэтэд тийм тэгэхдээ энийг тийм би яг нөгөө асуултыг нь хариулт сонсоогүй болохоор дутуу хариулчихлаа. Үйлдвэр гэхэд энэ бол хэцүү. Олон улсын зэрэглэлээр энэ бол зүгээр тийм цех.

Т.Энхтүвшин: Ойлголоо ойлголоо. Пүрэвдорж гишүүнд Уул уурхайн яамнаас бас бичгээр хариултыг нь өгчхөөрэй за юу.

Тэгээд та хэд энэ үйлдвэр байгаа юу гээд асуугаад байна шүү дээ Уул уурхайн яамаа, Баярмандал дарга үйлдвэр байгаа юу гээд асуугаад байна. Тэгээд юу гэдэг юм тэр Говьсүмбэрт байж байгаа хольж байгаа асуудал, Төв аймгийн Баян сумд байж байгаа бас энэ хольж байгаа асуудал, Зүүн Замын-Үүдэд бас байж байгаа хольж байгаа асуудал энэ үйлдвэр мөн юм уу, биш юм уу. Хэрвээ үйлдвэр мөн юм бол зураг хөргийг нь аваад Пүрэвдорж гишүүнд танилцуулаадхаач наадхаа.

Би бол юу гэдэг юм Дорноговь аймгийн Засаг дарга байж байхдаа тэр үйлдвэрийг бас харж байсан. Тэр үйлдвэр

гэхэд бас хэцүү шүү. Зүгээр дизелийн түлш тэр том савандаа хийгээд, дээр нь тэр керосин ч гэдэг юм уу янз янзын юмаа хийгээд тэгээд доороо сэнстэй юм шиг байгаа юм. Тэгээд хольдог тэгээд эргүүлээд юу гэдэг юм буцаагаад зардаг тийм л юм байгаа шүү дээ. Үйлдвэр гэж хэлэхэд бас маш хүнд шүү тэр асуудал чинь.

Тэгэхээр Монголд энэ чиглэлийн үйлдвэр бол байхгүй. Харин тэр хольдог савууд бол байгаа юм шиг байгаа юм. Тэгэхээр энэ асуудлынхаа бас зааг, ялгааг гаргаад тэгээд Пүрэвдорж гишүүнд танилцуулаарай. Сая бол тодорхой асуулаа шүү дээ. Монголд яг ингээд холиод хийдэг ийм шатахууны үйлдвэр байна уу, байхгүй юу гээд л асуугаад байна шүү дээ. Тэр байгаа бол тэр шатахууных нь үйлдвэрийг юу гэдэг юм зургийг нь аваад, ажлын хэсэг явуулаад ингээд танилцуулах хэрэгтэй. Үйлдвэр байхгүй бол байхгүй гэдэг юмнуудаа бичгээр юу гэдэг юм Пүрэвдорж гишүүнд саналаа хүргүүлэх хэрэгтэй.

Асуулт хангалттай юу Пүрэвдорж гишүүн нэмж асуух уу. Ажлын хэсгийн 7 дугаар микрофон дахиад хариулаадах.

Л.Баярмандал: Яг газрын тос боловсруулах үйлдвэр бол Дорноговь аймгийн Алтаниширээд байгуулагдаж байгаа нэг л үйлдвэр байгаа. Одоогийн ажиллаж байгаанууд нь үйлдвэр биш цехүүд. Зүгээр хольдог цехүүд л байгаа. Тийм, доороос нь сэнс тавьж л хольдог гэсэн. Үйлдвэр биш цехүүд л дээ. Одоо юу гэж хэлэх үү.

Т.Энхтүвшин: Уул уурхайн яам бичгээр хариултыг нь өгөөрэй. Ер нь бол Монгол Улсад үйлдвэр бол байхгүй шүү. Цех гэж хэлэхэд ч бас хэцүү шүү ер нь бас. Зүгээр хэдэн савууд байгаа. Тэгээд доороос нь сэнсээр ч юм уу эргүүлээд найруулдаг ийм л асуудал байж байгаа.

Тэгээд нэг ажлын хэсэг явуулъя даа Баярмандал даргаа. Энийг нэг талд

нь гаргая. Үйлдвэржилтийн байнгын хорооноос ажлын хэсэг гаргаад тэр Дорноговь аймгийн Замын-Үүдэд байж байгаа үйлдвэр яг үйлдвэр мөн юм уу, биш юм уу. Үйлдвэр биш шүү дээ. Тэрний газар дээр нь очиж үзье. Говьсүмбэрт байж байгаад очиж үзье, энэ Төв аймгийн Баян суманд байж байгаад очиж үзье. Өөр хаана байдаг юм тэгээд энийг газар дээр нь үзье.

Гишүүд асуулт асууж дууслаа. Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгдсэн тайлан болон аудитын дүгнэлттэй холбогдуулаад үг хэлэх гишүүд байна уу. Үг хэлэх гишүүд алга байна.

Монгол Улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Монгол Улсын Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцсэн талаарх Байнгын хорооноос гарсан санал, дүгнэлт, дүгнэлтийг Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд Улсын Их Хурлын гишүүн Ж.Батжаргал танилцуулна.

Монгол улсын 2022 оны нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэж дууслаа.

Гишүүдэд баярлалаа. Ажлын хэсэгт баярлалаа.

12.39 цаг

ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ
БУУЛГАЖ ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ Д.ОТГОНДЭЛГЭР

